

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2022.04.22

Улаанбаатар хот

Тус компанийн Хувьцаа Эзэмшигчдийн ээлжит Хурлыг, хурал хийхээр товлосон зарын дагуу 2022.04.22 ны өдрийн 14 цагт Компанийн хурлын танхимаас цахим хэлбэрээр шууд дамжуулав.

Хурлын дэгийн дагуу хурал эхлэхээс өмнө Тооллогын Комисс Хувьцаа Эзэмшигчдийн Хуралд ирсэн хувьцаа эзэмшигчдийн ирцийг бүртгэж, саналын эрхийн тоо, хурлын ирц, Тооллогын Комиссын 2022.04.22 ны өдрийн "Хүчин төгөлдөрт тооцох тухай" №01 тоот тогтоолыг Тооллогын Комиссын дарга Б.Тэргэл уншиж танилцуулав. / Тогтоолыг хурлын материалд хавсаргав./

Тооллогын комиссын дарга Б.Тэргэл : Хувьцаа Эзэмшигчдийн Ээлжит Хуралд 1.023.703 ширхэг хувьцаа эзэмшсэн 3.950 хувьцаа Эзэмшигчдээс саналын эрх бүхий 734.100 ширхэг хувьцаа эзэмшсэн 143 хувьцаа эзэмшигч бүртгэгдсэн байна. Энэ нь нийт хувьцааны 71,7 % -ыг төлөөлж байна. Иймээс Компанийн тухай хуулийн 69-р зүйлийн 1-д заасан заалтыг үндэслэн "Хурал хүчин төгөлдөрт тооцсугай" гэв. Мөн манай компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2022.03.11 ний өдрийн "Хурал хуралдуулах тухай" тогтоолд санал авах сүүлийн хугацааг 2022.04.22 ны өдрийн 14 цагаар тогтоож өгсөн, бид 14 цагт хурал эхлэнгүүт саналыг тасалбар болгон "хурал хүчин төгөлдөрт тооцох тогтоол"-ыг гаргалаа. Тогтоолыг гаргаж, уншсанаас хойш саналаа өгсөн бол хүчингүйд тооцно гэдгийг онцлон тэмдэглэлээ.

Үүний дараа Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн тогтоолоор томилогдсон хурал дарга тус компаний дэд захирал, аж үйлдвэрийн гавьяат ажилтан Б.Бурмаа нээж үг хэлэв.

Хурлын дарга Б.Бурмаа : Бид цахимаар, энэ удаагийн хурлыг зохион байгуулж байна. Хувьцаа эзэмшигч та бүхэн маань "Талх Чихэр" ХК-ийн пэйж хуудсанд хандан цахимаар болон өөрийн биеэр саналаа өгөцгөөсөн, одоо хурлын үйл ажиллагаанд цахимаар оролцохыг урьж байна гэв. Дараа нь хурлын дэг, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн тогтоолоор томилогдсон хурлын тэргүүлэгчид, нарийн бичгийн дарга болон тооллогын комиссыг танилцуулж ажилдаа орохыг урив.

Хурал даргалагч Өнөөдрийн хурлаар:

1. Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд ТУЗ-өөс өгсөн дүгнэлтийг хэлэлцэн батлах
2. Компанийн 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах
3. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн гишүүнийг нөхөн сонгох, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2022 оны төсвийг батлах
4. Ногдол ашгийг нэгж хувьцаанд 250 төгрөгөөр хуваарилах асуудлуудыг хэлэлцэнэ гэсний дагуу хурлын дараалал ёсоор :
1. Компанийн 2021 оны үйл ажиллагааны тайлан болон компанийн 2022 оны төлөвлөгөөг Гүйцэтгэх захирал М.Базар-Ууган илтгэв.

2. Компанийн 2021 оны санхүүгийн тайлан болон Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс өгсөн дүгнэлтийг компанийн нягтлан бодогч Ундармаа тайлагнав.
3. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн гишүүнд нэр дэвшигчийн товч намтарыг ТУЗ-ийн хараат бус гишүүн, Нэр дэвшүүлэх хорооны дарга Д.Баярсайхан танилцуулав.
4. "Ногдол ашиг хуваарилах" тухай ТУЗ-ийн тогтоолыг уншиж танилцуулав.

Асуулт : Танай компани техник, технологи , тоног төхөөрөмж, үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд хэрхэн өөрчлөлт, шинэчлэлт хийгдсэн бэ?

Хариулт: /Ерөнхий технологич Д.Одонгэрэл/ Манай компани салбартаа загвар компани болох зорилт тавьсан, энэ хүрээнд ISO : 9001, 22000 стандартуудыг хэрэгжүүлсэнн бөгөөд түүнээс хойш нэлээдгүй ажил хийлээ. Жил бүр баталгаажуулалтын аудит орж, байнгын сайжруулалтыг хийж байгаа нь бүтээгдэхүүний амт чанарыг тогтмол барих үндсэн суурь болж байдаг. Өнгөрсөн жил нарийн боовны шинэ үйлдвэр ашиглалтанд оруулахаар 6 улсын 10 гаран мэргэжилтэн ирж ажилласан, тун удахгүй шинэ бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүлэхээр ажиллаж байна. Ингэснээр европ дах нарийн боовны хэрэглээг манай хэрэглэгчид өдөр дутамдаа хэрэглэх боломжтой болж байгааг хэлэхэд таатай байна. Цаашдаа хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн менежментийн тогтолцоо 45001 стандартыг хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

Асуулт: Өнгөрсөн хугацаанд танай компани "Шинэ бүтээгдэхүүн" зах зээлд нэвтрүүлэх тал дээр юуг анхаарч ажиллав?

Хариулт : Манай үйлдвэр Талр, Нарийн боов, Бялуу гэсэн үндсэн 3 чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна. Манай бүтээгдэхүүн бүх насны хүмүүст зориуландсан байдан бөгөөд өнгөрсөн жил хүүхдэд зориулсан "Амтлаг" брендийн бүтээгдэхүүнийг зах үзэлд шинээр гарган хэрэглэгчдээс сайшаал хүртээд байна.

Асуулт: Хувьцааны ноогдол ашгаа яаж авах вэ?

Хариулт: Энэ жил нэгж хувьцаанд 250 төгрөг хуваарилахаар шийдвэрлэсэн. Хувьцаа эзэмшигч та бүхэн Пүрэв гариг бүр авах боломжтой. Хэрэв өмнөх жилүүдийнхийг аваагүй бол нөхөж олгоно.

Асуулт: 2020, 2021 онуудад Ковид цар тахлын дэгдэлттэй хүнд цаг үед Талх Чихэр компани тасралтгүй ажилласан. Цар тахал та бүхэнд ямар шинэ сорилт, сонголтыг авч ирсэн гэж үзэж байна вэ?

Хариулт : /Маркетингийн албаны дарга Л.Баттөр/ Манай компани хүнсний хангамж хариуцсан үүрэг хүлээсэн үйлдвэрлэгчийн хувьд өнгөрсөн жил хил, гаалийн удаашрал, тээвэр, шатахуун, валютын үнийн өсөлт, ажиллах хүчний хомсдолтой хүндхэн байсан хэдий ч бид үйлдвэрлэлийн үйл ажиллагааг тассалдуулахгүй хэвийн явуулах бүхий л нөөц боломжоо дайчлан ажиллаж ирсэн.Нөгөө талаараа цар тахлын нөлөөгөөр хэрглэгч, харилцагч нар зөвхөн гурил байгаад талх болдоггүй гэдгийг ойлгосон байх. Учир нь талх үйлдвэрлэхэд гурилаас гадна тоног төхөөрөмжийн найдвартай ажиллагаа, сэлбэг хэрэгсэл, бусад түүхий эд материал, ажиллах хүч, үйлдвэрийн орчин, технологи, сав баглаа боодол, хүргэлт тээвэрлэлт гээд маш олон хүчин зүйл оролцож бий болдог. Цар тахал үүссэн хүнд үед биднийг дэмжин хамтран ажиллаж ирсэн хэрэглэгч, харилцагч, хувьцаа эзэмшигч нартаа талархал илэрхийлье.

Хурлын дарга : Өөр санал хүсэлт байхгүй тул санал хүсэлтийг үүгээр тасалъя. Та бүгдэд баярлалаа. Одоо түр завсарлая, тооллогын комиссыг ажилдаа орохыг урья гэв.

Үүний дараа тооллогын комиссын дарга Б.Тэргэл " Саналын хуудсыг тоолж, дүнг танилцуулах" тухай тогтоолыг уншиж танилцуулав.

Компанийн нийт 1.023.703 ширхэг хувьцаа эзэмшиж буй 3.950 хувьцаа эзэмшигчдээс хуралд 734.100 ширхэг хувьцаа эзэмшсэн 143 эзэмшигч оролцов. Тооллогын комисст ирсэн саналын хуудас 143 ширхэг, үүнээс асуулга тус бүрээр хүчинтэй саналын тоо 733,674 буюу хуудасны тоо 130 ширхэг, асуулга тус бүрээр хүчингүй саналын тоо 426 буюу хуудасны тоо 13 байна.

1. Компаний 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлахыг зөвшөөрсөн 733,674 ширхэг хувьцаа буюу нийт саналын 100 хувь, татгалзсан, түдгэлзсэн саналын тоо байхгүй.
2. Компанийн 2022 оны бизнесийн үйл ажиллагааны төлөвлөгөөг батлахыг зөвшөөрсөн 733,662 ширхэг хувьцаа буюу нийт саналын 99,998 хувь татгалзсан санал байхгүй, түдгэлзсэн 12 ширхэг хувьцаа буюу нийт саналын 0,002 хувь
3. Компанийн ТУЗ-ийн 2022 оны зардлын төсвийг 51.240.000 төгрөгөөр батлахыг зөвшөөрсөн 2733,662 ширхэг хувьцаа буюу нийт саналын 99,998 хувь, татгалзсан, түдгэлзсэн саналын тоо байхгүй.
4. Компанийн ТУЗ-ийн ердийн гишүүнээр:
 - Le Goff Didier-ийг сонгохыг зөвшөөрсөн 733.599 ширхэг хувьцаа буюу нийт саналын 99,99 хувь, татгалзсан санал байхгүй, түдгэлзсэн 75 ширхэг хувьцаа буюу нийт саналын тоо 0,01хувь
5. Нэгж хувьцаанд оногдох ногдол ашгийг 250 төгрөгөөр хувиарлахыг зөвшөөрсөн 733.505 ширхэг хувьцаа буюу нийт саналын 99,977 хувь, татгалзсан санал байхгүй, түдгэлзсэн 169 ширхэг хувьцаа буюу нийт саналын 0,023 хувь байгааг үндэслэн

ТОГТООХ НЬ: Дээрх хэлэлцсэн асуудлаар Тогтоол гаргуулахаар хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулсугай гэж танилцууллаа.

Тооллогын Комиссын дүнг үндэслэн Хувьцаа Эзэмшигчдийн Ээлжит Хурлаас №01 тоот тогтоол гаргав.

Хувьцаа Эзэмшигчдийн Хурлаас ТОГТООХ НЬ :

1. Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд ТУЗ-ийн өгсөн дүгнэлтийг зүйтэй гэж үзсүгэй
2. Компанийн 2022 оны төлөвлөгөөг баталсугай.
3. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн гишүүнээр:
 - Le Goff Didier-ийг компанийн дүрэмд зааснаар 3 жилийн хугацаатай сонгосугай
4. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2022 оны төсвийг 51.240.000 төгрөгөөр баталсугай.

ХУРЛЫН ДАРГА

ТЭМДЭГЛЭСЭН

У.ӨЛЗИЙБАЯР